



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар E/20

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайд асан Жаргалтулгын Эрдэнэбат нь 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр албан тушаалаасаа огцорч, Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч байх үедээ 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр өөрийн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглан, Засгийн газрын тогтоол гарган нөхөх олговрын талбайн солбицол баталж өөрийн харьяа агентлаг болох Ашигт малтмал, газрын тосны газраар дамжуулан “Элбэг орд” ХХК-д стратегийн ач холбогдол бүхий Нарийнсухайт ордын хилийн дотор “Улаан сайр-1”, “Улаан сайр-2” талбайг тус тус олгож, улмаар 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Ж.Эрдэнэбат өөрөө 31 хувь, төрсөн дүү Ж.Эрдэнэтөгс 69 хувийг нь тус тус эзэмшдэг “Хэрх-Илч” ХХК-ийн нэр дээр шилжүүлэн авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан “Улс төрд нөлөө бүхий этгээд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэгт холбогдсон байна.

Уг хэрэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад Улсын Их Хурлын гишүүний тангараг өргүүлж, төрийн хамгаалалтад авч хаацайлах гэж буй явдлыг дэмжихгүй байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүх эрх мэдлийг Улсын Их Хурал буюу угтаа эрх баригч нам, түүний улс төрчдөөс нэн хамааралтай болгож, шүүх болон шүүгчдийг хууль бусаар тагнан чагнаж, нөлөөлөл үзүүлсний улмаас авлига, албан тушаалын гэмт хэрэгтнүүд суллагдах, ял завших боломж бүрдээд байна гэж үзэж байна.

Ж.Эрдэнэбат Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөснөөр хуулийн хамгаалалтад орж, холбогдсон гэмт хэргийг нь шударгаар шийдвэрлэж чадахгүйд хүрнэ.

2021000146

Улсын Их Хурлын дарга Та 3 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэхдээ “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг “амилуулах”, нийгмийн шударга ёсны захиалгыг хангах, шударга ёсны “цангаа”-г тайлах, шударга, хараат бус шүүхтэй болох ёстой” гэж мэдэгдсэн билээ. Гэтэл авлига, албан тушаалын хэрэг нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа Ж.Эрдэнэбатыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй бүрэн эрхийн хамгаалалтад авч байгаа нь таны ам, ажил зөрж байгааг нотолж байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг бол энгийн нэг хулгайлах гэмт хэрэгтэй жиших аргагүй, улс орны аюулгүй байдалд заналхийлдэг хор уршигтай гэмт хэрэг. Монголын ард түмэн “уут уут мөнгөөр улсаа худалддаг сайд гуай” хэмээх дуу хүртэл зохиож, хойч үедээ анхааруулж ирснийг мартаж болохгүй.

Иймд Ж.Эрдэнэбатын холбогдсон гэмт хэргийг нь эцэслэн шийдвэрлүүлэх хүртэл Улсын Их Хурлын гишүүний тангараг өргүүлэх гэж байгааг таслан зогсоож, хойшлуулах саналтай байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА